



АЙТҮҮЛС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 3-р сарын 6-ны өдөр

Дугаар 24/006

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60-р зүйлийн 60.1, 60.2, 64-р зүйлийн 64.2, 65-р зүйлийн 65.4, 71-р зүйлийн 71.1, 71.2, 71.3, 76-р зүйлийн 76.1.2, 76.1.3, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.27, 7.31, “Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллаганы журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3-р сарын 6-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Айтүүлс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4-р сарын 19-ний өдрийн Баасан гарагт 10:00 цагт Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн гудамж-8, Континентал зочид буудал, 2 давхарт байрлах хурлын тэнхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 2.1. Компанийн 2023 оны бизнесийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - 2.3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.4. Компанийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
 - 2.5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - 2.6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, сонгох;
 - 2.7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг батлах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 3-р сарын 29-ний өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар болон хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалт, бусад холбогдох мэдээллийг Хавсралт 1-ээр баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг Хавсралт 2-оор баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцохгүй ч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийг хуралд оролцсонд тооцох ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2024 оны 4-р сарын 18-ны өдрийн 13:00 цаг хүртэл байхаар тогтсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Хатанболдыг, Тооллогын комиссын даргаар Ш.Батдэмбэрэлийг, тооллогын комиссын гишүүнээр Х.Уянга, О.Билигсайхан нарыг тус тус томилсугай.
8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга: Д.Жигжид
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Г.Янжилхам, Т.Энхмаа
9. Энэхүү тогтоолын шийдвэр, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг СЗХ-ноос баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлэх, холбогдох талуудад хүргүүлэх ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Г.ХАТАНБОЛД